



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 0/395

Баруун-Урт сум

Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл
мэндийн төвийн бүтэц орон тоог батлах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.1.5-ын "б", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дах заалт, Засгийн газрын 2019 оны 25, 276 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/37, А/38 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог нэгдүгээр, Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Б.Эрдэнэтуяа/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/74 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ЭРДЭНЭБААТАР

Аймгийн Засаг даргын 0220 оны 07 дугаар
сарын 06-ны өдрийн 4/398 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, орон тоо

№	Үйл ажиллагааны чиглэл	Орон тоо	Цалингийн зэрэглэл
1	Төвийн дарга	1	ТҮЭМ-7
2	Статистик бүртгэл мэдээллийн ажилтан	1	ТҮЭМ
3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хариуцсан эмч	1	ТҮЭМ
4	Хүүхэд, Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж хариуцсан эмч	1	ТҮЭМ
5	Халдварт бус өвчин, үндэсний хөтөлбөр хариуцсан эмч	1	ТҮЭМ
6	Халдварт өвчний асуудал хариуцсан эмч	1	ТҮЭМ
7	Дархлаажуулалт, тарилгад халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан эмч	1	ТҮЭМ
8	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, олныг хамарсан үеийн хариу арга хэмжээ, онцгой нөхцөлийн тайван цагийн бэлэн байдал хариуцсан эмч	1	ТҮЭМ
9	Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан эмч	1	ТҮЭМ
10	Лабораторийн их эмч	1	ТҮЭМ
11	Нян судлалын лаборант	1	ТҮЭМ
12	Эрүүл зүйн лаборант	1	ТҮЭМ
13	Орчны эрүүл мэндийн лаборант	1	ТҮЭМ
14	Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ
15	Хүн амын эрүүл мэндийн тандалт судалгаа, гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ
16	Хүнсний аюулгүй байдал, эрүүл хооллолт хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ
17	Нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ
18	Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ
19	Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ
20	Хэвлэлийн эх бэлтгэгч, график дизайнер, дуу дүрсний техникч	1	ТҮ



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/20

Баруун-Урт сум

Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоонд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь хэсэг, Засгийн газрын “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 417 дугаар тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022 оны 487 дугаар тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн “” А/37 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын “Үүрэг даалгавар өгөх тухай” 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1а/228 дугаар албан даалгавар зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Эрүүл мэндийн газарт шилжин ирсэн орон тоогоор Эрүүл мэндийн газрын бүтцэд Хяналт шалгалтын хэлтсийг нэмсүгэй.

2. Эрүүл мэндийн газрын нийт Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын жагсаалтыг төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд нийцүүлэн өөрчилсүгэй.

3. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Дэлхийцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/395 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын
2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн
А/20 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын ангилал, зэрэглэл
1	2	3	4
1	Эрүүл мэндийн газрын дарга	1	T3-4
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтэс			
2	Хэлтсийн дарга	1	T3-6
3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, эрсдэл, үнэлгээ яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
4	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
5	Халдварт өвчин, эмнэлгийн дотоод халдварын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
6	Эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
7	Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
8	Сувилахуйн тусламж, ахмад настны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
9	Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
10	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
11	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс			
12	Хэлтсийн дарга	1	T3-6
13	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
14	Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээллийн мэргэжилтэн (улсын байцаагч)	1	T3-9
15	Мэдээллийн технологи, эрүүл мэндийн мэдээний сан, зайн анагаах ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
Хяналт шалгалтын хэлтэс			
16	Хэлтсийн дарга	1	T3-6
17	Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч	1	T3-7
18	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (халдвар судлалын хяналтын асуудал хариуцсан)	1	T3-7
19	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (орчны эрүүл ахуйн асуудал хариуцсан)	1	T3-7
20	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (хүнсний эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын асуудал хариуцсан)	1	T3-7
21	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын асуудал хариуцсан)	1	T3-7
Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс			
22	Хэлтсийн дарга	1	T3-6
23	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-9

1	2	3	4
24	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
25	Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж, барилгын чанар аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
26	Хууль эрх зүй, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
27	Салбарын болон байгууллагын санхүүгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэл	1	TY-8
28	Архив, бичиг хэргийн ажилтан	1	TY-5
29	Даргын туслах	1	TY-4
30	Нярав	1	TY-4
31	Жолооч	2	TYЭМ-2
32	Үйлчлэгч	3	TY-1
33	Жижүүр	3	TY-1
Нийт		38	

-----oOo-----